

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,203,737...



ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

Худалдах үнэ 500 төг

2018.05.09. Лхагва. №092 (4942)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongoliinmedeesonin@gmail.com

- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин



20 дахь жилдээ



С.НАРАНГЭРЭЛ:

Р.Чойномын мөрдөн байцаалт
бүхэлдээ яруу найраг

–Түүний хавтаст хэрэг шиг хэргийг хэзээ ч
уншиж байгаагүй–



Б.ПҮРЭВЖАВ
b.puuravjav11@gmail.com

Энэ удаагийн “Сондгой өнцөг” буландаа
Академич С.Нарангэрэлийг урьж ярилцлаа.

–Тантай энэ удаад хууль, сургууль, боловсрол
ярихгүй. Харин урлаг, яруу найраг, ном зохиолын
талаар ярьж болох уу?

–Их сонирхолтой булан байна. Би яруу найрагт их
дуртай. Энэ сэдэв нь илүү таалагдаж байна. Би арван
жилийн сурагч байхдаа хуульч болно гэж бодож
байсангүй. Үнэнийг хэлэхэд, хуулийн мэргэжлийг үзэн
яддаг байсан ч гэж хэлж болно.

Үргэлжлэл нь V нүүрт

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД



Үргэлжлэл III нүүрт

ДОТОР НҮҮРТ

VIII НҮҮРТ:

ЕРӨНХИЙЛӨГЧӨӨ
МАНАЙ АЙМГИЙН
ДИНОЗАВРЫН
ХӨШӨӨНД ЦЭЦЭГ
ӨРГӨ

...Нэгэнт “эцэг өвгөд”-
өө хүндлэх ёстой
юм чинь Баянхонгор
аймагт байдаг
динозаврын хөшөөнд
ч цэцэг өргөхөд
буруудахгүй. Хүй
нэгдлээс өмнө хор-
воо дэлхийд байсан
нь үнэн юм чинь
хүндлэхэд гэмгүй...

TISSOT CHRONO XL.
A 45MM CASE.

T + TISSOT

#ThisIsYourTime

SWISS WATCH SHOP I: НАРАН МОЛЛ, СӨҮЛИЙН ГУДАМЖ
SWISS WATCH SHOP II: НАРАН ЦЕНТР, УИД-Н БАРУУН ТАЛД

TISSOTWATCHES.COM
TISSOT. INNOVATORS BY TRADITION

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Сүрьеэ судлалын орчин үеийн сурах бичигтэй боллоо

Х.БОЛОРТЭНГИС

Эрүүл мэндийн салбарт сүрьеэ судлалын цогц мэдээллийг агуулсан орчин үеийн сурах бичиг хэвлэгдэн гарсныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалтын албанд өчигдөр хүлээлгэн өглөө. Сүрьеэтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах үүднээс Анагаах ухааны доктор, дэд профессор Г.Цогт “Сүрьеэ судлал” сурах бичгийг анагаах ухааны их, дээд сургуулийн оюутан, сүрьеэгийн эмч нарт зориулан бичиж, өчигдөр танилцуулж буй нь энэ ажээ. Г.Цогт нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад сүрьеэгийн зөвлөхөөр ажиллаж байх хугацаандаа Төв Азийн гурван оронд сүрьеэ судлалын сурах бичгийг боловсруулан гаргасан нь нийт таван удаа хэвлэгджээ. Тэрбээр Сүрьеэ, уушгины өвчинтэй тэмцэх олон улсын холбооны “Нийгмийн эрүүл мэндийн шагнал”-ыг хамгийн анх хүртсэн бөгөөд одоо сүрьеэгийн зөвлөх мэргэжилтнээр ажилладаг аж. Монгол Улс нь сүрьеэгийн өвчлөлөөр дэлхийн 201 орноос 37-д жагсдаг бөгөөд эхний 36 орны 22 нь Африк тивийн нэн ядуу улсууд байна. Сүүлийн жилүүдэд сүрьеэгийн эсрэг арга хэмжээ эрчимтэй хийгдэх болсон ч анагаах ухааны их, дээд сургуульд ирээдүйн эмч, мэргэжилтэнг бэлтгэх сүрьеэ судлалын цогц сурах бичиг өнөөдрийг хүртэл хомс байжээ.

Монгол Улс агаарын бохирдлоороо хоёрдугаарт бичигджээ

Г.САНЖААХАНД

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хамгийн цэнгэг болон агаарын бохирдолтой улс, орнуудыг нэрлэжээ. Судалгаанаас хамгийн цэнгэг агаартай улс Хойд Америк, Европт байгаа бол эсрэгээр агаарын бохирдол ихтэй орнууд Ази, Африкт ихэвчлэн байгаа нь ажиглагдсан байна. Харин Монгол Улсын хувьд хамгийн их агаарын бохирдолтой улсын жагсаалтад хоёрдугаарт бичигджээ. Дэлхийн хүн амын 10 хүн тутмын нэг нь бохирдсон агаараар амьсгалж байгаа бөгөөд жил бүр долоон сая хүн агаарын бохирдлоос үүдэлтэй эмгэгээр нас бардаг аж.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Т.БАТБОЛД: ШҮҮЛТҮҮРИЙН АППЛИКЕЙШНЫГ СУУЛГАСНААР ХҮҮХДИЙНХЭЭ ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭГ ХЯНАХ БОЛОМЖТОЙ



Х.БОЛОРТЭНГИС

bolorkhand0726@gmail.com

Тэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран интернэтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шүүлтүүрийн програмлыг нэвтрүүлж байгаа билээ. Энэ талаар Харилцаа холбооны зохицуулах хорооны мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч Т.Батболдоос тодруулаа.

-Хүүхдүүд нь интернэт ашиглахдаа ямар сайтад хандалт хийж байгаа тухай мэдээлэл эцэг эхийн утсанд очдог аппликейшн бий болгоно гэж байсан. Уг аппликейшн хэрэглээнд нэвтэрсэн үү?

-Насанд хүрэгчдэд зориулсан цахим хуудаст хүүхэд нэвтэрсэн тохиолдолд эцэг эхийнх нь гар утсанд мессэжээр мэдэгдэл очдог шүүлтүүрийн аппликейшн хийхээр төлөвлөж байсан. Гэвч төсөв мөнгөнөөс эхлээд шийдэгдэхгүй асуудлууд гарч ирсэн учраас хүүхдийн цахим хандалтын мэдээллийг хадгалдаг шүүлтүүрийн программыг хийхээр болсон. Гар утсанд мессэжээр очсон мэдэгдлийн төлбөрийг хаанаас, хэн гаргах вэ гэх мэт асуудал их байсан тул өөр хэлбэрийн аппликейшн хийж байна. Бидний хийж буй аппликейшныг эцэг, эхчүүд гар утас, компьютертоо суул

гаад насанд хүрэгчдэд зориулсан, хүүхдэд хориотой сайтад хандалт хийж болохгүй тохиргоог хийнэ. Ингэснээр тухайн төхөөрөмжөөс хориглосон сайт руу хандалт хийж болохгүй бөгөөд ямар сайтад хандалт өгсөн тухай бүх мэдээлэл хадгалагдаж үлдэнэ. Эцэг эхчүүд хадгалагдсан мэдээллийг хараад, хянаад явж болно.

-Хэзээнээс хэрэглээнд нэвтрүүлэх вэ, одоогоор аппликейшныг бүтээх ажил хэдэн хувьтай явж байна?

-Одоогоор судалгаа нь хийгдээд явж байна. Ямар ч байсан энэ ондоо багтааж хэрэглээнд нэвтрүүлэх зорилт тавьсан байгаа.

-Насанд хүрэгчдэд зориулсан сайт руу нэвтрэхийг хориглосон гадаадын маш олон шүүлтүүрийн апп байдаг. Та бүхний хийж буй апп үүнээс юугаараа өөр байх вэ?

-Гадны орнуудын нэвтрүүлсэн

...Уг аппликейшныг гар утас, суурин болон зөөврийн компьютертээ суулгаад шүүлтүүрийн тохиргоог эцэг эхчүүд өөрсдөө хийх ёстой. Ингэснээр насанд хүрэгчдийн сайтад зөвхөн өөрийн нэвтрэх нэр, нууц үгээ оруулж байж хандалт хийх боломжтой болох эсвэл огт хандалт өгч болохгүй байдлаар ч тохиргоог хийж болно...

шүүлтүүрийн программууд олон бий. Үнэтэй, үнэгүй гээд олон төрөлтэй. Үнэтэй аппликейшн нь хэдийгээр маш сайн ажиллагаатай боловч хэтэрхий өндөр үнэтэй байдаг.

Харин үнэгүй апп нь гацах, шаардлагатай шүүлтүүрийг хийж чаддаггүй гэх мэт олон асуудал байдаг. Хамгийн гол нь бүгд гадаад хэлээр байдаг тул Монголын хэрэглэгчид ашиглахад бэрхшээлтэй байдаг учраас татаж аваад, ашиглаад явна гэдэг хэцүү. Тиймээс бид Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хэрэглэгчийн шүүлтүүрийн монгол аппликейшн хийе гэж санаачилсан юм. Ард түмэндээ хэрэглэхэд хялбар, ухаалаг гар утас болон бүх төрлийн компьютерт суух боломжтой аппликейшн хэлбэрээр хийж байна.

-Та бүхний хийж буй аппликейшн ямар үнэтэй байх вэ?

-Иргэдэд үнэгүй татуулахаар төлөвлөж байгаа. Хамгийн гол нь тухайн аппликейшныхаа чанарт маш их анхаарч байна.

-Монгол хэлтэй шүүлтүүрийн программ өмнө нь гарч байсан уу?

-Монголчуудын бүтээсэн, монголхэлтэйшүүлтүүрийн аппликейшн гэж байхгүй. Бидний хийж байгаа энэ аппликейшн анхных. Уг аппликейшныг гар утас, суурин болон зөөврийн компьютертээ суулгаад шүүлтүүрийн тохиргоог эцэг эхчүүд өөрсдөө хийх ёстой. Ингэснээр насанд хүрэгчдийн сайтад зөвхөн өөрийн нэвтрэх нэр, нууц үгээ оруулж байж хандалт хийх боломжтой болох эсвэл огт хандалт өгч болохгүй байдлаар ч тохиргоог хийж болно.

PHOTO NEWS



Эрүүл мэндийн салбарт шударга үнэлэлтж тогтоохыг шаардан сувилагч нар жагслаа.

НИЙГЭМД ЦӨӨН МӨРӨӨР

- Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, АШУУИС хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, нотолгоонд суурилсан судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор “Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл 2018” онол практикийн хурлыг өчигдөр зохион байгууллаа.
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, нийслэлийн Мал эмнэлгийн газар хамтран Баянгол, Хан-Уул дүүргийн гэр хорооллын айл өрхийн нохойг бүртгэлжүүлэх, үржил хэжгаарлах ажлыг өнгөрсөн сарын 30-наас хэрэгжүүлж эхэлсэн. Өнөөдрийн

байдлаар тус арга хэмжээ 34.7 хувьтай байгаа бөгөөд ирэх сарын 10-ныг хүртэл хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байгаа аж.

- Нийслэлийн хэмжээнд 14 хоногийн хугацаанд объектын гал түймрийн 132, техникийн холбогдолтой осол, аврах ажиллагааны 20, нийт 152 удаагийн дуудлага ирсэн байна. Дуудлагын дагуу нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын алба хаагчид үүрэг гүйцэтгэн, 102 иргэний амийг авран хамгаалжээ.
- Хөвсгөл нуурыг хуванцар хог хаягдлаар бохирдуулан, экосистем, амьтан, ургамлыг сүйтгэж байгааг Женевийн Их сургуулийн эрдэмтэд судлан тогтоосон байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Хот жишиг гудамжтай болно

Г.САНЖААХАНД

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зүүн дөрвөн замын уулзвараас Сансарын тойрог хүртэлх гудамжийг “Жишиг гудамж” болгон тохижуулж эхэлжээ. Уг ажлын хүрээнд зүлэгжүүлэлт хийх, ургамлан хашлага тарих, зүүн талаар 950 метр үргэлжлэх туслах замыг өргөтгөх, 150 автомашины зогсоол байгуулж авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх, явган зам тавих ажлыг хийх аж. Тохижилтын ажил хийхтэй холбогдуулан тохижилтын ажлын трассд орсон 24 ТҮЦ, нэг объектыг буулгах ажлыг Нийслэлийн газрын албатай хамтран зохион байгуулсан байна. Түүнчлэн, газар чөлөөлж, инженерийн шугам сүлжээ шилжүүлэх, тохижилтын ажил хэвийн явах нөхцлийг бүрдүүлэх талаар ТҮЦ эзэмшигч иргэдэд удаа дараа шаардлага хүргүүлсэн аж. Гэвч долоон ТҮЦ эзэмшигч иргэд төрийн байгууллагын зүгээс тавьж буй шаардлагыг эс биелүүлэн тохижилтын ажлын төлөвлөгөөт хугацааг 14 хоногоор зогсоосон байна. Улмаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн газрын алба, Баянзүрх дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэс хамтран албадан нүүлгэж, тохижилтын ажлын трассыг чөлөөлснөөр авто замын чучилтын ажил бүрэн дууссан байна.

ЗАР

-13-р хороололд шинээр ашиглалтад орсон байранд 40м2 2 өрөө орон сууц зарна. Үнэ 84 сая. /хувь лизинг хийх боломжтой/

Утас: 99145060

-ХУД, 120 мянгатад хуучны гал тогоо тусдаа 3 өрөө байр яаралтай зарна. Үнэ 110 саяас. **Утас: 99145060**


-Хуучин дамбын эцэст хөл хөдөлгөөн ихтэй үйлчилгээний 2 давхар 252 м2 объект, 600 м2 газрын хамт худалдана. Үнэ 360 саяас Жич: үх чиглэлээр ашиглах боломжтой, бартер оролцуулах боломжтой. /Сарын түрээсийн орлого 4 сая/ **Утас: 99145060**

-“Bella Vista”-д тансаг зэрэглэлийн 244 м2 дуплекс орон сууц түрээслүүнэ. Жич: тавилгатай, урсгал зардал үнэд багтсан. /Сарын түрээс 7 сая/ **Утас: 99145060**

-Залуус хороололд 20.5 м2 1 өрөө байр хямд худалдана. /Үнэ 31 саяас/ **Утас: 99145060**

-10 хороололд цэлгэр, саруулхан, том зайтай 64.5 м2 2 өрөө байр зарна. /М2 үнэ сая 450./ **Утас: 99145060**

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД



Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, С.Зоригийг хөнөөсөн хэргийг илрүүлэх ажлын хэсгийн ахлагч Г.Эрдэнэбат “С1” телевизийн “Цензургүй яриа” нэвтрүүлэгт оролцох үеэрээ С.Зоригийн хэрэгт холбоотой өмнө нь дэлгэгдэж байгаагүй ноцтой баримтуудыг дэлгэсэн юм. Түүний хэлсэн ноцтой баримтуудыг түүвэрлэн хүргэж байна.

ЦЕНЗУРТЭЙ ЭШЛЭЛ



-1998 оны аравдугаар сарын 03-ны өдөр С.Зоригийн амь насыг хөнөөсөн хэрэгт мөрдөн байцаагчийн тогтоолоор эрүүгийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхэлсэн. Өнгөрсөн 18 жилийн хугацаанд уг хэргийг долоон удаа түдгэлзүүлж, долоон удаа буцаан сэргээсэн. Гэхдээ уг хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, гүйцэтгэх ажиллагаа нэг өдөр зогсоогүй.

-Хууль зүйн сайд Ц.Нямдоржийн тушаалаар С.Зоригийн хэргийг шалгах ажлын хэсэг өөрчлөгдөж байгаагүй. Гэхдээ Ц.Нямдоржийг Хууль зүйн сайдаар ажиллаж байх үед дөрвөн удаагийн тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байсан.

-С.Зоригийн амь насыг хөнөөсөн хэрэг тодорхой шатандаа илэрсэн. Бид гүйцэтгэгчийг илрүүлж, шалгаж, нотлоод шүүхээр шийдвэрлүүлсэн. Одоо захиалагчийг олох ажил үргэлжилж байгаа.

-Хэргийн газарт прокурор, шинжээч, цагдаагийн албан хаагч зэрэг 17 хүн орсон. Мөн УИХ, Засгийн газрын гишүүн, талийгаачийн гэр бүл, хамаатан садан, нэг намын нөхөд гэх мэт 57 хүн нэвтэрсэн байдаг. Хэргийн газраас С.Зориг болон Б.Булган нарын хурууны хээ олддоогүй. Тэр олон хүмүүс хэргийн газарт хөлхсөнөөс болоод хурууны хээ олддоогүй байж магадгүй.

-Хэргийн газраас олдсон хурууны хээнүүд тухайн аллагыг үйлдсэн гурван гүйцэтгэгчийн гарын хээтэй тохироогүй.

-С.Зоригийн хэргийг шалгаж байсан хүмүүсээс золгүй байдлаар амиа алдсан хүмүүс бий. Гэхдээ энэ хэргийг шалгаж байсны улмаас нас барсан гэх баримт байхгүй.

-С.Зоригийн хэргийг би үйлдсэн гэж 7-8 хүн хандсан. Мөн энэ хэргийг сайн мэднэ, тэр хүн үйлдсэн гэх маш их мэдээлэл өнгөрсөн хугацаанд ирсэн. Энэ бүхнийг бид нягталж шалгасан. Нарийн хэлбэл 41 хүнийг сэжигтнээр татан шалгахад хэрэгт холбогдолгүй нь тогтоогдсон учраас хэргийг хаасан.

-Т.Чимгээг С.Зоригийн хэрэгт холбогдуулан шалгаж байх үед түүний охин автын ослоор нас барсан. Гэхдээ Дарханы замд болсон золгүй ослыг энэ хэрэгт нааж болохгүй. Харин Т.Чимгээгийн гэрийн хашаанаас цогцос олдсон гэдэг нь үнэн. Уг хэргийг үйлдсэн хүмүүс Т.Чимгээг болгоомжлуулах зорилгоор хийсэн байх гэж харддаг.

-Ц.Амгаланбаатар бусдыг санаатайгаар алсан хэргээр шоронд сууж байхдаа Б.Содномдаржаатай удаан хугацааны турш мессэжээр маргалдсан байдаг. Ц.Амгаланбаатар “Та нар намайг удаан хугацаагаар эргэж тойрсонгүй. Би энэ хэргийг илчилнэ, хэлнэ” гэж мессэж бичсэн байсан.

-Хүн амины хэрэг үйлдэх үедээ Б.Содномдаржаа 24, Т.Чимгээ 26, Ц.Амгаланбаатар 16 настай байсан. Б.Содномдаржаа хэрэг үйлдсэн гэдгээ хүлээсэн. Т.Чимгээ энэ хэргийг шалгаж байх үед энэ хэргийг үйлдсэн талаархи хангалттай олон баримт нотолгоог гаргаж өгсөн. Харин мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэг өгөхөө больсон.

-2017 оны долдугаар сарын 04-нд Т.Чимгээ прокурорт гаргасан өргөдөлдөө “Т.Чимгээ миний холбогдсон энэ хэрэгт нар нь холбогдолтой хамтран оролцогч байсан ба энэ хэргийг захиалсан гэгдэж, яллагдагчаар шалгагдаж байсан эдгээр хүмүүсийг дахин шалгуулах хүсэлтэй байна” гэсэн өргөдлийг гаргасан. Тус өргөдлийн дараагаас хэвлэл мэдээллээр Т.Чимгээг зохиомлоор яллалаа гэдэг мэдээлэл цацагдаж эхэлсэн. Мөн өргөдөл гаргаснаас хойш дөрөв хоногийн дараа Т.Чимгээгийн ар гэрийнхэн түүнтэй түр уулзалт хийсэн. Уг уулзалтаас хойш Т.Чимгээ ярих зүйлгүй болчихсон байсан.

-Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийг гүтгэх шинжтэй үйлдлийг Ц.Нямдорж, Ж.Батзандан, Л.Болд нар хийж байгаа. Мөн ялтнуудын ар гэрийнхэн, хуулийн байгууллагынхан хүртэл оролцож байгаа. Эдгээр хүмүүст эрүүгийн хэрэг үүсгэн шалгаад явж байгаа. Үйлдлийг нь нотолно. Тэдгээр хүмүүст хууль зүйн хариуцлага хүлээлгэх ёстой.

-Т.Чимгээ прокурорт хэргийг дахин шалгуулах хүсэлт тавьчихаад ар гэрийнхэнтэйгээ уулзсаны дараа хүсэлтээсээ татгалзчихсан. Гэрийнхэн нь түүнтэй уулзаад юу ярьсан. Ямар мэдээлэл өгсөн болоод түүнээсээ буцсаныг тогтооно. Ямар хүний уршгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учирсныг нотолбол дээрх хүмүүсийг буруутгах үндэслэл болж болно. Тэгээгүй тохиолдолд ямар нэгэн хүн өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд С.Зоригийн хэргийг шийдвэрлэхдээ хүн хэлмэгдүүлсэн байна гээд ярьсан болгоныг барьж аваад шоронд хийнэ гэвэл маш том алдаа болно. Хардах үндэслэл байгаа гэхдээ нотолж чадаагүй байна.

-Б.Булганыг анх гэрчээр байцааж байгаад сүүлдээ хамжигч байж болзошгүй гэж үзээд яллагдагчаар татан шалгасан. Гэвч хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр хэргийг 2016 оны хоёрдугаар сард хэрэгсэхгүй болгосон. Харин одоо захиалагчийг тогтоох ажлын хүрээнд шинэ нотлох баримтаар яллагдагчаар татан шалгаж байгаа.

-Сэжигтнүүдийн аман зургийг Б.Булганы мэдүүлгийн дагуу зураач Ц.Байдыгаар зуруулсан. Ам зураг тухайн үед сэжигтнүүдийг харсан гэх хоёр гэрчүүдийн мэдүүлэгтэй тохирсон.

-Б.Булган 1998 оноос хойш гэрчийн мэдүүлэг өгч ирсэн. Харин хэргийг сэргээж шалгаж эхэлснээс хойш олон удаа мэдүүлэг өгөөгүй.

-С.Зориг агсныг хөнөөх хэргийг маш нарийн бодож төлөвлөж хийсэн. Захиалагч нь дам дамандаа захиалга өгөөд яахаас буцахгүй болчихсон ойрын харилцаатай хэдэн хүнээр хийлгэсэн нь тогтоогдсон.

-Энэ хэргийн эзэн холбогдогчид тухайн үедээ цагдаагийн байгууллага давын өмнө эрж хайх хүмүүс байгаагүй. Хүний амь битгий хэл хулгай дээрмийн хэрэгт ч холбогдож байгаагүй цагдаа, тагнуулын байгууллага эрж хайх боломжгүй хөдөөний малчин хүмүүсийг сонгож хийлгэсэн байдаг.

-С.Зоригийг хөнөөсөн хүмүүсийн мэдээлэл тагнуулын байгууллагаар бус ШШГЕГ-ын албан хаагчаар анх дамжиж ирсэн. Уг мэдээллийг шалгаад гүйцэтгэх ажиллагааг явуулж эхлэхээр С.Зоригийн алагатай холбоотой гэх бусад баримтууд гарч эхэлсэн.

-Б.Содномдаржаа, Т.Чимгээ, Ц.Амгаланбаатар нарыг таниулах ажиллагаанд таван хүнийг оролцуулахад гурав нь шууд заасан. Нэг хүн нь эргэлзсэн, нөгөө хүн нь татгалзсан.

-Шүүх ажиллагааг хаалттай явуулсан нь хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, хавтаст хэрэгт төрийн нууцтай холбоотой мэдээ баримт орсон. Хоёрдугаарт, шүүх хурлыг олон нийтэд ил явуулчихвал захиалагч олдхогүй болчих учраас хаалттай явуулсан. Захиалагчийг олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг явуулж байгаа.

-1889 онд байгуулагдсан Олон улсын парламентийн холбоо гэж бий. Энэ байгууллага энх тайвныг хамгаалах, парламентыг бэхжүүлэх зорилготой төрийн бус байгууллага. С.Зоригийг хөнөөсөн хэргийн дараа Монголын парламент тус байгууллагад уг хэргийг илрүүлэхэд арга зүй болон техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэгч гэсэн хүсэлтийг тавьсан юм билээ. Үүний дагуу Герман, Солонгос, АНУ-аас экспертээ ирүүлж, мөн ДНК шинжилгээг хийж өгсөн байдаг. Манайх нэгэнт туслалцааг нь авсан учраас жил бүр хэргийн явцын талаар тайлангаа өгдөг байсан. Гэтэл сүүлийн үед энэ байгууллага уг хэргийг шалгадаг байгууллага болж хувирсан.

-Аль ч улс аливаа хэргээ бусад улсын оролцоогүйгээр шийдэж байж тусгаар улс гэж явдаг. Монгол Улс шүүх эрх мэдлийн байгууллагатай. Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүхээрээ уг хэргийг шийдчихсэн байхад ямар нэгэн гадны байгууллагад танай шүүх хэргийг буруу шийдчихжээ гэх эрх байхгүй. Монгол Улс УДШ-ийн шийдвэрийг Олон улсын парламентын холбоо хянаж болно гэсэн хууль гаргасан тохиолдолд л манайхыг хянаж болох байх.

-Энэ байгууллагад Монголын улстөрчид нэг талыг барьсан мэдээлэл өгч, түүгээрээ дамжуулан Зөвлөмж гаргуулах байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хичээж байгаа.

ҮЗЭЛ БОДОЛ

УИХ тарах нүхээ ухаж эхэллээ



Н.ПУНЦАГБОЛД
puntsagaa1985@gmail.com

Монгол Улс авлигын индексээрээ 180 орноос 103 дугаар байрт эрэмбэлэгдсэн. 2015 оноос хойш өнгөрсөн жил хүртэл 31 байраар ухарчихаад байгаа. МАН 2016 оны

сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулж, Засгийн эрх авсан. Тэд төрийн эрх авсандаруйдаа буюу 2016 оны долдугаар сард АТГ-ын даргыг сольж, Т.Энх-жаргалыг томилсон. Тэглээ гээд ч Монгол Улсын авлигын индекс сайжирсангүй. Дахиад 16 байраар ухарч, одоо бид 103-т эрэмбэлэгдэж байна.

Ердөө л энэ үзүүлэлт АТГ ажлаа хийж чадахгүй байгааг хангалттай илтгэж байгаа хэрэг. Түүнээс гадна, Ерөнхийлөгч Х.Баттулга, ард иргэдийн дийлэнх хувь нь АТГ-ыг ажлаа

хийж чадахгүй байна гэж дүгнэсэн.

Үргэлжлэл нь VI нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ШҮҮХ, ШҮҮГЧ ХОЁРООС АЙХ ХЭРЭГГҮЙ


Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ
ts.chandmanierdene@gmail.com

Шүүхийн ерөнхий зөвлө-
лөөс “Шүүхийн иргэдийн
төлөөлөгчдийн нийслэлийн
зөвлөгөөн”-ийг өчигдөр зо-
хион байгууллаа. Зөвлөгөөнд
2018 онд Дархан-Уул, Орхон,
Төв аймаг болон нийслэлийн
шүүх хуралдаанд оролцсон
120 гаруй иргэдийн төлөөлөгч
оролцож шүүн таслах
ажиллагаа дахь иргэдийн
төлөөлөгчдийн оролцоо,
тулгамдаж буй асуудлыг
хэлэлцсэн юм.

*Шүүхийн ерөнхий
зөвлөлийн Гүйцэтгэх
нарийн бичгийн дарга
Т.Мэндсайхан зөвлөгөөнийг
нээж хэлсэн үгэндээ
“Иргэдийн итгэл
хүлээсэн, шударга ёсны
баталгаа болсон шүүхийн
тогтолцоог бүрдүүлэхийн
тулд шүүн таслах
ажиллагаанд ирээд оролцох
аргыг ашиглаж байна”
хэмээсэн юм. Өдөрлөгийн
үеэр түүнтэй уулзаж цөөн
асуултад харуулт авлаа.*

Т.Мэндсайхан:
Шударга ёсны тухай
ойлголт хүн бүрт
байдаг



**-Шүүхийн иргэдийн тө-
лөөлөгчөөр сонгогдох
иргэнд тавигдах шаард-
лагын талаар дэлгэрэнгүй
мэдээлэл өгнө үү?**

-Шүүхийн иргэдийн
төлөөлөгч нь ял шийтгүүлж
байгаагүй, эрх зүйн бүрэн
чадамжтай, 25 нас хүрсэн
Монгол Улсын иргэн байна.
Тухайн шатны шүүхийн
харьяаллын нутаг дэвсгэрт
байнга оршин суудаг иргэн
сүүлийн нэг жилийн хугацаанд
иргэдийн төлөөлөгчөөр шүүх
хуралдаанд оролцоогүй байх
ёстой юм.

**-Шүүхийн иргэдийн
төлөөлөгчөөр шүүх хуралд
оролцож байгаа иргэд
хууль эрх зүйн ямар
төвшний мэдлэгтэй байх
ёстой вэ?**

-Иргэдийн төлөөлөгч
нь заавал хууль мэдэх
шаардлагагүй. судлахад
их цаг зарцуулдаг учир
төгс сайн мэдэх албагүй.
Суурь мэдлэгтэй байхад
хангалттай. Хамгийн гол нь
иргэн амьдралын туршлага,
шударга ёсны талаар
баримтлах мэдлэгтэй байж,
юу зөв юу бурууг ялгаж
мэддэг байх ёстой. Шударга

ёсны тухай ойлголт бүх хүнд
байдаг.

**-Шүүхийн шинэчлэлийн
хүрээнд хийгдэж байгаа
сүүлийн үеийн ажлуудаас
товч дурьдвал?**

-Гурван зүйлийг нэрлэнэ.
Нэгдүгээрт иргэдийн төлөө-
лөгчийг шүүх хуралдаанд
оруулах үйл ажиллагаа
илүү сайжирч санамсаргүй
түүврийн аргаар сонгодог
болсон. Иргэдийн санал
дүгнэлтийг шүүх бүрэл-
дэхүүн хүлээж авдаг
соёлыг төлөвшүүлэхээр
ажиллаж байна. Хоёрдугаарт
шинжээчийн дүгнэлтийг
жишиг байдлаар урьдчилан
гаргах бөгөөд маргаж
байгаа талууд дүгнэлтийг
нээлттэй байдлаар ашиглах

...Анх утсанд
дуудлага ирээд
шүүхээс ярьж
байна гэхэд
хэсэгхэн зуур
шоконд ордог
юм билээ. Юу
билээ яасан
болохоор
шүүхээс дуудлага
ирдэг билээ
гэж жийрхсэн.
Эрх үүрэгтэйгээ
танилцсаны
дараа тайвширч
иргэний үүргээ
биелүүлсэн...

нөхцлийг анхаарч ажиллаж
байна. Гуравдугаарт
шүүхийн шийдвэр гарсны
дараа шийдвэр гүйцэтгэл
хангалтгүй байна. Бидний
хийсэн судалгаагаар иргэний
хэргийн шүүхийн шийдвэрийн
биелэлт 50 хувьд хүрэхгүй
байна. Цаашид шүүхийн
шийдвэр хэрэгжихэд
дөхөмтэй байх шийдвэрийг
бичих талаар анхаарч
ажиллаж байна. Шүүхээр
шийдүүлж дууссан хэрэг
дээр хэргийн хөдөлгөөний
удирдлага хөтөлж байгаа нь
шүүхийн хянан шийдвэрлэх
ажиллагаа хуульд заасан
хугацаанд хэрэгжиж байгаа.

**Шүүх байгууллагад
итгэх иргэдийн тоо
гурав дахин өссөн**

“Шүүн таслах ажиллагаа
дахь иргэдийн төлөөлөгчийн
оролцоо, тулгамдаж буй
асуудал”-ын талаар Шүүхийн
ерөнхий зөвлөлийн Иргэдийн
төлөөлөгч хариуцсан ахлах
шинжээч Б.Мөнхзаяа мэдээлэл
хийхдээ “2008-2010 онуудад
Монгол Улсын шүүхийн
байгууллага, шүүгчид итгэх
итгэлийн талаар судалгаа авах
үед нийт иргэдийн 20 хүрэхгүй
хувь нь шүүхэд итгэдэг гэж
хариулжээ. 2016-2017 онд
авсан судалгаагаар 60 гаруй
хувь нь шүүх байгууллага
болон шүүгчид итгэдэг гэсэн
дүн гарсан. Энэ нь шүүхийн
итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр
иргэд сонгогдон ажилласан
үр дүн хэмээн дүгнэж байна.
Шүүхийн иргэдийн төлөөлөгч
эрүүгийн хэрэгт гэм буруугийн
талаар, захиргааны хэрэгт
захиргааны талаар дүгнэлтээ
гаргадаг. Тиймээс иргэдийн
төлөөлөгчийн дүгнэлт чухал.
Программаар сонгогдсон
иргэдийн төлөөлөгч үүргээ
биелүүлэх шаардлагатай, ийм
боломжоор ажил олгогч хангах
учиртай” хэмээв.

**Иргэдийн
оролцоотой шударга
шүүхийн тогтолцоог
бэхжүүлнэ**

“Би бодохдоо шүүгч гэдэг
хүнийг ууртай ширүүн харцтай,
хөндий хүйтэн харилцаатай,
харахад сүрдмээр, хүрэхэд хол
гэж санагддаг байлаа. Шүүхийн
иргэдийн төлөөлөгчөөр санам-
саргүй байдлаар сонгогдон
шүүх хуралд анх удаа оролцож
үзэхэд төсөөлснөөс өөр байлаа”
хэмээн шүүхийн иргэдийн
төлөөлөгчөөр ажилласан иргэд
ярьж байсан юм.

Зөвлөгөөнд оролцогч 21 иргэн
нээлттэй хэлэлцүүлэгт саналаа
хэллээ. Баянгол дүүргийн иргэн
н.Дэлгэр “Анх утсанд дуудлага
ирээд шүүхээс ярьж байна гэхэд
хэсэгхэн зуур шоконд ордог юм
билээ. Юу билээ яасан болохоор
шүүхээс дуудлага ирдэг билээ
гэж жийрхсэн. Эрх үүрэгтэйгээ
танилцсаны дараа тайвширч
иргэний үүргээ биелүүлсэн.
Шүүхийн итгэмжлэгдсэн төлөө-
лөгчөөр сонгогдсон иргэнд
өгдөг урамшуулал инээдтэй
байсан. Урамшууллын хөлсөө
нэмэгдүүлж ажиллахыг хүсч
байна” хэмээв. “Шүүхийн
иргэдийн төлөөлөгчдийн
нийслэлийн зөвлөгөөн”-ий
төгсгөлд Шүүхийн ерөнхий
зөвлөлийн дарга Н.Лүндэндорж
үг хэлэхдээ “Шүүхийн иргэдийн
төлөөлөгчийн таслах эрхийг
хассан Үндсэн хуулийн цэцийн
шийдвэр нь Монгол Улсын
шүүхэд шударга ёс оруулж
ирэхийг түдгэлзүүлсэн
харамсалтай шийдвэр болсон.
Шударга ёсны талаархи
үйл ажиллагаанд том саад
бэрхшээл учирсан. Гэхдээ
бидэнд том хүч байна. Шүүхийн

итгэмжлэгдсэн төлөөлөгч та
бүхний адил 12000 шүүхийн
иргэдийн төлөөлөгч шүүгчийг
шүүх ажиллагаа явуулах үед,
хөндлөнгөөс хурц хараагаар
хянаж, санаа бодлоо хэлнэ
гэдэг нь том хүч юм. Иргэдийн
төлөөлөгч та бүхэн Монголын
шүүхийн шинэчлэлд шударга
ёсыг нэвтрүүлэх шүүгч нарын
шүүн таслах үйл ажиллагаанд
явуулах, үйл ажиллагаанд
Монгол Улсын иргэдийн зүгээс
тавьж байгаа хамгийн том
хяналт” хэмээв. Тэрбээр мөн
шүүхийн иргэдийн төлөөлөгч
нь шийдвэр гаргах эрхгүйгээр
хувьд чадамжтай болгохоор
УИХ-ын хууль санаачлагчийн
төвшинд уриалга хүргүүлэхээ ч
мэдэгдэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Б.Булганаас байцаалт авчээ

С.БУДРАГЧАА

ТЕГ өчигдөр УИХ-ын
гишүүн, Дэд бүтцийн
сайд асан С.Зоригийн
хамтран амьдрагч
Б.Булганаас байцаалт
авчээ. Байцаалт 14.00
цагийн үед эхэлж, 16.45
цагт дууссан байна.
УЕПГ-аас “С.Зоригийн
амь насыг хөнөөсөн онц
ноцтой гэмт хэргийн
захиалагчийг тогтоох
ажлын явцад уг хэрэгт
Б.Булган хамжигчаар

оролцсон байж магадгүй
гэх шинэ нотлох
баримт гарч ирсэн тул
яллагдагчаар татсан”
хэмээн мэдэгдээд байгаа
юм. Б.Булган нь 1998
оноос хойш уг хэрэгт
гэрчийн мэдүүлэг
өгсөөр ирсэн бөгөөд
захиалагчийг тогтоох
ажил эхэлснээс хойш
олон удаа мэдүүлэг
өгөөгүй хэмээн УЕП-
ын орлогч Г.Эрдэнэбат
мэдэгдсэн байдаг.

Зургаан настай хүү гал алдсанаас дөрвөн хүн амиа алджээ

Х.БОЛОРТЭНГИС

“Сүхбаатар дүүргийн
13 дугаар хороонд 8х6
хэмжээтэй байшин
шатаж, дөрвөн хүн нас
барлаа” гэх дуудлага
даваа гарагийн
/2018.05.07/ өглөөний
10:27 цагт цагдаагийн
байгууллагад иржээ.
Дуудлагын дагуу галын
шинжээч, шинжээч
эмч нарыг оролцуулан
хэргийн газрыг шалгахад
гэр бүлийн дөрвөн хүн
угаартан нас барсан
байжээ. Тодруулбал, тус
айлын зургаан настай
хүү амбаарт цаас шатааж
байхдаа гал алдсаны
улмаас гэр бүлийн

гишүүд нь угаартан нас
барсан гэсэн урьдчилсан
дүгнэлт гарсан
байна. Цагдаагийн
байгууллагаас өгсөн
мэдээллээр галын
улмаас тус тоотод
оршин суух 56 настай
эрэгтэй Э, 55 настай
эмэгтэй Д, 61 настай
эрэгтэй Н, 54 настай
эрэгтэй Т нар угаартан
нас баржээ. Одоогоор
хэргийг Сүхбаатар
дүүргийн цагдаагийн
хоёрдугаар хэлтэст
үргэлжлүүлэн шалгаж
байна. Мөн тус айлын
зургаан настай хүүхэд
галд өртөөгүй эсэн мэнд
үлдсэн гэдгийг албаны
эх сурвалж мэдээллээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 5 дугаар сарын 09-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Багийн номны хэвлэлийн эх бэлтгэх тухай дотоодын нээлттэй тендер шалгаруулалт
Тендер шалгаруулалтын дугаар: ХЭБ-2018/001-007

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх
бүхий тендерт оролцогчдоос Монгол Улсын төсвийн
санхүүжилтээр 2018 онд шинээр зохиосон ерөнхий
боловсролын сургуулийн сонгон судлах хичээлийн
14 нэрийн багийн ном тус бүрийн хэвлэлийн эхийг
бэлтгэж нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.
Тендер шалгаруулалт нь 7 багц бүхий 1 тендер байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах
ажилгааны цахим системээр зарлагдаж байгаа цахим
тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй
мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.
Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар
тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулах зохион
байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг
илгээхийн өмнө 50,000.00 Тавин мянга/ төгрөгийг
цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын
дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Сүүлийн 2 (2016, 2017 он) жилийн борлуулалтын орлогын
дундаж хэмжээ нь тендерийн тухайн багцад санал болгож
буй үнийн дүнгээс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой
ээзлийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 60%-тай
тэнцүү ба түүнээс дээш хэмжээтэй байна.

Сүүлийн 2 (2016, 2017 он) жилийн санхүүгийн
аудитлагдсан тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 (2016, 2017 он) жилийн хугацаанд энэхүү

тендер шалгаруулалтаар гүйцэтгэх ажилтай адил хамгийн
багадаа 1 гэрээг гүйцэтгэсэн байх бөгөөд түүний үнийн дүн
нь санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.

Тендерийн хамт дээрх хүснэгтэд багц тус бүрээр заасан
дүнтэй тэнцэх тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн
материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх
шаардлагагүй бөгөөд цахим систем цахим тендерийн
баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас
тендерт оролцогчийн цахим тендерийн баталгааны талаарх
мэдээллийг шалгана.

Тендерийг 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн
11.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд
оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан
тендерийг 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн
11.30 цагт нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад
мэдээллийг доорх хаягаар авч болно.
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44, Засгийн газрын III
байр, 5 дугаар давхар, 516 тоот өрөө
Ерөнхий боловсролын бодлогын газрын Утас 318131,
Цахим хаяг: www.tender.gov.mn

2018 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн энэхүү тендерийн
урилгыг хүчингүйд тооцож байна.

ЗАЛРУУЛГА

“Тус сонины 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн № 088/4938 дугаарын
6 дугаар нүүрт нийтлэгдсэн Deawoo-BE-106, Хьондай каунти, МА3-215067
маркийн автобусны сэлбэг худалдан авах” тухай Б-ЗТН-2018-01/03 тоот
тендерийн урилгад

1. Тендерийг [2018-06-04-ний өдрийн 09:00 цаг]–аас өмнө доорх хаягаар ирүүлэх
ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг
[2018-06-04]-ний өдрийн, [10:00 цаг]-т нээнэ хэмээснийг

2. Тендерийг [2018-06-08-ний өдрийн 09:00 цаг]–аас өмнө доорх хаягаар ирүүлэх
ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг
[2018-06-08]-ний өдрийн, [10:00 цаг]-т нээнэ. Хэмээн хугацааг уртасгаж
залруулж байна.

МЭДЭЭЛЛИЙГ ДООРХИ ХАЯГААР АВНА УУ.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж,
“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ өөрийн байр,
216 тоот өрөө, Хөрөнгө оруулалт, хангамжийн албаны худалдан
авах ажиллагааны мэргэжилтэн Э.Одонтулгалаг
Утас: 77110052, 98002008 И-мэйл: odno1018@yahoo.com



С.НАРАНГЭРЭЛ: Р.ЧОЙНОМЫН МӨРДӨН БАЙЦААЛТ БҮХЭЛДЭЭ ЯРУУ НАЙРАГ

–Түүний хавтаст хэрэг шиг хэргийг хэзээ ч уншиж байгаагүй–

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Аав минь Монголын нэртэй хуульч, эрдэмтдийн нэг Содовсүрэн гэж хүн байлаа. Тухайн үедээ БНМАУ-ын Дээд шүүхийн орлогч даргаар ажилладаг байсан юм.

-Дургүй атлаа яагаад энэ мэргэжлийг эзэмшсэн юм бэ?

-Энэ их учиртай. Аавын талын хамаатны хүүхдүүд мөрийтэй тоглоом, малын хулгайн хэрэгт холбогдож, хоригдохоор болсон юм. Тэр үед ар гэрийнхэн нь ааваас туслахыг гуйхад, “Би мэдэхгүй. Монголын шүүх мэднэ” гэж хэлж байсан. Гэтэл авга эгчийн нөхөр нь манайд халамцуу ирж, аавыг минь цус нөжтэй нь хутгалдтал зодчихоод “Чамаас цусан төрлөө салгалаа. Ах дүүс байж яахаараа тусалдаггүй юм. Наад хэдэн хүүхдийг чинь сайн сайхан явахыг харна” гэж хэлээд хаалга өшиглөөд гарч байв.

Ийм нөхцөл байдлыг дэргэдээс нь харж байсан учраас хуульч болохгүй гэж боддог байсан хэрэг. Тэгээд л сурагч байхдаа яруу найраг, уран зохиол, түүхийн чиглэлээр өөрийгөө бэлдэж, ЕБС-на төгсөөд МУИС-ийн Монгол хэл, Уран зохиолын ангид элсч байлаа.

-Та өөрийнхөө хүсэл мөрөөдлийг дагаагүй шалтгаан нь юу байв?

-Нэг өдөр аав өрөөндөө дуудлаа.

гарна, бүгдийг нь уншдаг байлаа. Би утга зохиолд жигтэйхэн их дуртай байсан юм. МУИС-ийг төгсөөд, сургуульдаа багшилсан. Мөн УЕП-ын Шүүн таслах ажиллагаанд, хяналт хариуцсан удирдах албан тушаалтай байсан юм. Тэгэхэд 1980-аад оны дундаас хойш Р.Чойном яруу найрагчийг хэлмэгдүүлсэн тухай ам дамжин яригддаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл нь их гардаг. Миний хувьд ч гэсэн оюутан байхдаа Р.Чойномын хаалттай шүлгүүдийг уншдаг, цээжилдэг байсан. Хөдөө, сангийн аж ахуй явахдаа их уншина. Би Р.Чойномын бичсэн шүлгээр нь маш их бахархдаг юм. Ингээд 1980-аад оны сүүлчээр би Р.Чойномын хэрэг гэж ямар зүйл байгааг судалж эхэлсэн. Энэ хэрэг Аюулаас хамгаалах яамны архивт онц нууцын ангилалтай байлаа. Р.Чойном яруу найрагчийг БНМАУ-ын эсрэг сурталчилгаа явуулсан, төрийн эсрэг онц хүнд хэргээр чанга дэглэмтэй хорих ангид, таван жил хорих шийдвэр гаргасан байсан юм. Ийм онц нууц хэргийг УЕП-оос татаж хянадаг байсан. Би УЕП-т ороод Р.Чойномын хэргийг татаж, уншсан. Би олон хавтаст хэрэг уншсан даа. Гэвч Р.Чойномын хавтаст хэрэг шиг хэргийг хэзээ ч уншиж байгаагүй.

-Үзэл суртлын хатуу чанга үе байсны шинж байх. Бичсэн зүйлийнхээ төлөө ялтуулна гэдэг ой

найраг.

-Тэгнэ шүү дээ. Яруу найраг бичсэнийх нь төлөө шийтгэж байгаа юм чинь тайлбар нь тийм байхаас өөр яалтай билээ?

-Улс төрийн гэмт хэрэгтнүүдийг ганцааранг нь хорьдог байсан. Тухайн үед жижиг, цаас харандаа олдвол шүлгээ бичдэг байсан байгаа юм. Тэгээд хянагч нар орж ирээд, шүлгийг нь хурааж аваад, мөрдөн байцаагч нарт өгдөг. Байцаагчид он, сар, өдрийг нь бичээд хавтаст хэрэгт хавсаргасан байдаг. Тэнд хаана ч ил гараагүй шүлгүүд байдаг юм. Тиймээс би Р.Чойномыг уран бүтээл, итгэл үнэмшлээр нь шийтгэсэн байна гэж үзээд цагаатгах асуудлыг УДШ –д оруулахаар УЕП-оос санал явуулсан. Тухайн үед цаг нь болоогүй ч гэсэн хожимоо цагаатгасан юм. Тэгээд би хавтаст хэргийн тэмдэглэлтэй л үлдсэн.

-Р.Чойномын бүтээлийг уншаагүй, мэдэхгүй хүн байхгүй. Энэ хүний гомдлыг та тайлж чаджээ. Хэлмэгдүүлэлт гэдэг сайрхаад байх зүйл биш?

-1980-аад оны сүүлчээр Монголын яруу найргийн загаламжилсан эцэг гэж үзэж болох Д.Пүрэвдорж ахтай таарсан. Д.Пүрэвдорж ах миний аавын найз байгаа юм. Намайг хүүхэд байхаас л мэднэ. Гэтэл Д.Пүрэвдорж ах “Сая би хөөцөлдөж яваад Монголын

Би хоёр сар суугаад, номынхоо гар бичмэлийг Д.Пүрэвдорж ахад аваачиж өгсөн юм. Би “За ах минь наадах чинь болохгүй болсон бол шууд миний гар нооргийг ураад хогийн саванд хийчихээрэй” гэж хэлээд гараад явсан. Гэтэл хэд хоногийн дараа Д.Пүрэвдорж ах “Чамд жаахан юм байна. Одоо ном чинь хэвлэлтэд орж байна” гэх нь тэр. Тэгээд 1990 онд “Р.Чойномд тулгасан ял” гэсэн ном 50 мянган хувь хэвлэгдэж, Монголд ардчилал, шинэчлэл бүх зүйлийг эхлүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн. Тухайн үед Японы монголч эрдэмтэд Япон улсад хэвлүүлсэн. Өвөрмонголд хэвлэгдэж гарсан. Ингэж би байгалиас надад заяасан нэг хувь авьяасыг жижигхэн сорилт болгосон юм. Монголын зохиолчид, яруу найрагчид надад маш их хүндэтгэлтэй ханддаг. Магадгүй тэр эрхэм хүнийг цагаатгуулж чадсанд талархдаг байх.

-Харин та дууны үг бичиж байв уу?

- Би аавынхаа нутгаар бол Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүн. Аавын минь нутгаас дуучид, уран бүтээлчид их төрдөг. Тиймээс би богино дууны хөгжмийн их мастер гэж хэлж болох УГЗ Д.Баттөмөр ахад одоогоос 45 жилийн өмнө нэг шүлэг өгсөн. Тэгээд “Би амьддаа ганцхан дууны шүлэг бичнэ. Монголд эх орон, хайр сэтгэл, аав ээжийн тухай маш олон дуу байна.

тантай уулз гэж байна гээд нөгөө нотыг минь дутгуйнд хийгээд өгсөн. Тэгэхээр нь би “С.Жавхлан гавьяатад хэлээ. Ар монголын дуу дуулаачдаас та ганцхан нь биш. Хэзээ нэгэн цагт энэ үгийг, том уран бүтээлчийн зохиосон аяыг дуулах аавын хүү гарах байлгүй дээ” гэж хэлээд явуулсан. Одоо энэ дууг чөлөөт уран бүтээлч н.Ариунболд дуулж байгаа. Сайхан бүтээл болоод дуулагдаж байна. Миний уран бүтээлтэй холбоотой зүйл энэ л байна. Өөр ч нэг сонирхуулаад байх зүйл алга даа.

-Хайрын шүлэгтэй юу?

-Үгүй ээ. Хүүхэд байхдаа л бичсэн байх. Одоо зав алга. /инээв/

-Монголын яруу найрагчдаас хэний бүтээлд илүү дуртай вэ?

-Ер нь Монголын яруу найрагчдаар бахархдаг. Сайхан залуу үе гарч ирж байна. Олон мундаг хүнээс тэр нь, энэ нь гээд онцлогүй. Бүгд сайхан шүү дээ.

-Дэлхийн найрагчдаас хэн байна вэ?

-Оросын алдарт зохиолч Есенин, Сергей Александрович, Лермонтов, Михаил Юрьевич нарт их дуртай. Мөн унасан газар, угаасан ус, төрөлх эх орныхоо, ард түмнийхээ бусдаас ялгарах өвөрмөц онцлогыг магтан дуулсан шүлэг, яруу найрагт их дуртай.

-Хуульч болоогүй байсан бол та үсээ урт ургуулчихсан, тамхи татаж, хаа нэг 100 татчихаад хэдэн шүлэг тэрлээд явах байсан байх.



Манайх хоёр хүү, таван охинтой өнөр өтгөн гэр бүл. Гэтэл аав “Хэн нэгийг чинь хуульч болгохгүй бол миний олон жил хураасан эдгээр ном үгүй болно. Би бодож, бодож чамайг МУИС-ийн хуулийн ангид сургахаар боллоо. Өнөөдөр МУИС-ийн профессор Д.Цэвэгмид багштай уулзсан. Сургалтгын тэтгэлэг, ангийг чинь хуулийн ангид шилжүүлсэн” гэж хэллээ. Би тэр шөнө аавтайгаа хүний эрхийн төлөө тэмцэл хийсэн. Уйлж орилоод л, хачин авир гаргаж их л эсэргүүцсэн. Харин аав “Нус нулимсаа тат. Хэзээ нэгэн цагт чи надад залбирна” гэж хэлсэн. Эцэг хүний эрс хатуу шийдвэр үр хүүхдийнх нь амьдралын замыг заадаг юм билээ. Ер нь үр хүүхэд эцгийнхээ нэрийг амьдруулдаг юм байна. Ингээд л миний хуульч болох зам мөр нээгдсэн. Ийм л түүхтэй.

-Яруу найраг, утга зохиол, хүсэл мөрөөдөл, тэмүүлэл юу болсон бэ?

-Хүүхэд байхдаа Монголын яруу, найраг, зохиолын ямар л шинэ бүтээл

тойнд баймгүй зүйл шиг санагддаг. Гэвч бидэнд ийм үе байсан гэж бодохоор л...?

-Тийм ээ. Р.Чойномыг хоёр шүлгээр нь шийтгэсэн байдаг. Тухайлбал, ...Уур минь хүрч байна.

Уур минь шатаж байна
Улаан тутгаас үнтэй амьд
Улаан зүрх минь шатаж,
Уужим дэлхийд би шатаж байна
Нэг даваанд өссөн үе чацуутан

Нэг тогоонд хооллосон ахан дүүс... гээд явж өгнө. Нөгөөх нь өөрөө өөртөө унших шүлэг юм. Шүлгэнд засаг төрийн харилцаа, ЗХУ-ын эрх баригч нарын явуулж байгаа бодлого, үндэсний өв соёлыг дорд үзэж байна гэсэн утгатай зүйлийг бичсэн байдаг. Гэтэл байцаагчид шүлгийг нь мөр мөрөөр нь агуулгыг нь тайлбарлуулж, мөрдөн байцаалтыг явуулсан юм билээ. Өөрөөр хэлбэл, Р.Чойном яруу найрагч өөрийнхөө шийтгүүлсэн шүлгийн агуулга бүрийг мөрдөн байцаах газарт тайлбарлаж өгсөн байдаг юм. Тэр мөрдөн байцаалт бүхэлдээ яруу

уран зохиол гэдэг эвлэлийн газрыг байгууллаа. Чи Р.Чойномын хэргийг хамгийн сайн мэдэх, цагаатгуулж явсан хүн. Манай эвлэлээс Р.Чойномын тухай баримтат тууж гаргах гэж байгаа, бичээч” гэсэн даалгавар надад өгсөн. “Ээ ах минь нэг мөр шүлэг хэвлүүлж үзээгүй би баримтат тууж яаж бичих вэ дээ” гэж хэлсэн. Үүний хариуд “Үгүй ээ, яах вэ. Утга зохиол, урлаг сонинд тэр жил хэвлэгдэх номын төлөвлөгөө гаргадаг байсан. Тэгээд уншигчдаас хамгийн олон санал авсан номыг нь хэвлэдэг. Тиймээс чи надад номынхоо гарчгийг хэлчих” гэсэн. Тэгээд би бодож, бодож, “Р.Чойномд тулгасан ял” гэж хэлсэн. Тэгээд хэсэг хугацаанд мартчихсан.

-Номоо мартчихсан юм уу эсвэл санаагаа мартчихсан хэрэг үү?

-Түүнээс хойш сар гаруй хугацаа өнгөрсний дараа Д.Пүрэвдорж ах гэр рүү утасдаж байна. “Нарангэрэлээ, энэ жил хэвлэгдэх номын хэмжээнд чинийх 28 мянган захиалагчийг олоод ирлээ. Одоо чи номоо бич. Оролдоод үз” гэсэн.

Гэтэл хүний ёс суртахуун жудгийн тухай шүлэг, дуу байхгүй байна. Би энэ орон зайд дууны үг бичнэ. Харин та ая хийгээд өгөөрэй” гэж хэлсэн. “Жудаг” дууны үгийн хэсгээс сонирхуулахад, ...Ардын холч ухаан
Андын элгэмсэг ёсон
Булгаж, тэрслээгүй эгэл зан
Бурууг ухааруулсан сэтгэлийн
Заяа тавиланг жудгаар тэгшлэдэг юм
Зүрх сэтгэлийг жудгаар хариулдаг юм... гээд үгэнд Д.Баттөмөр ах ая хийж өгсөн.

-Дуугаа хэнээр дуулуулсан юм бэ. Нэр болоод үг нь их содон юм?

-Би бодож, бодож МУГЖ С.Жавхлан энэ дууг дуулж чадна. Хоолойд нь нийцэх байх гээд С.Жавхлантай биечилж уулзсан. Ног, дууны үгээ ч үзүүлсэн. “Өө болно. Би ийм үгтэй дуу дуулна” гээд авсан. Тэгээд байдаггүй. Жил орчим сураггүй алга болсон.

-Дууны үг болоод нотыг чинь аваад уу. Тэгээд ингэж их удчихаад дуулаагүй юм уу?

-Тийм ээ. Нэг залуу С.Жавхлан гавьяат

Аягүй бол Б.Лхагвасүрэн гуайтай эн зэрэгцэхгүй зохиолч болох байсан болов уу?

-/Инээв/. Тийм мундаг хүнтэй эн зэрэгцэхгүй байсан байх. Гэхдээ Б.Лхагвасүрэн бид хоёр сайн найзууд. Эцэг өвгөд минь биднийг холбодог. Манай аав Төв аймгийн Шүүхийн даргаар ажиллаж байсан. Харин Б.Лхагвасүрэнгийн аав хэсгийн шүүхэд даргаар ажиллаж байсан юм. Монголын алдартай зохиолч. Ном бүтээлд нь би хачин их дуртай.

-Гоё шүлэг уншихаар огшоод, омогшоод явдаг мэдрэмж хэвээрээ биз дээ. Сонирхолтой зүйл гэдэг бол баргийн зүйлд чөдөрлүүлээд байдаггүйг мэднэ?

-Хэвээрээ. Би сүүлийн үед Монголын эртний яруу найраг, ёс суртахууны агуулгатай шүлэг, туульсыг нэлээд их судалж байна. Тэнд Монголын сэргэн мандалтын үеийн бичигдээгүй хууль байна. Биднийг ухааруулах ухаан энд байна.

ҮЗЭЛ БОДОЛ

УИХ ТАРАХ НҮХЭЭ УХАЖ ЭХЭЛЛЭЭ



Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Зүгээр гудамжаар явж байгаа захын хүнээс АТГ ажлаа хийж чадаж байгаа юу гээд асуу. Чадахгүй байгаа л гэж хэлнэ. Чадахгүйгээсээ гадна тэд хүсэхгүй байна. Гадаадад оффшор данс нээж, түүгээрээ хэдэн арван саяар нь ам.доллар гүйлгэж байгаа улстөрчдийн хэргийг ч шалгахыг хүсэхгүй байгааг бид харж буй. Тиймдээ ч Ерөнхийлөгч Х.Баттулга АТГ-ын даргыг солихоор санал хүргүүлж, ямар хүнийг томилох хүсэлтэй байгаагаа ч мэдэгдсэн. Нэрийг нь өргөн барьсан. Гэхдээ өөрөө дүр мэдэн нэг хүн санал болгоогүй. Ард иргэдээсээ санал авч, жинхэнэ ардчиллын аргаар томилох хүнээ сонгосон. Харамсалтай нь, Ерөнхийлөгчийн санал болгосон хүмүүсийг АТГ-ын удирдлагаар томилохыг МАН хүссэнгүй. Өчигдрийн Хуульзүйн байнгын хорооны хуралдаанаар АТГ-ын дарга, дэд даргыг томилох санал нь хууль зөрчсөн гэж үзэж, дэмжсэнгүй. Эрх баригчид л АТГ-ын дарга Т.Энхжаргалыг ажлаа сайн хийж байгаа. АТГ маш сайн ажиллаж байна гэж үзлээ. Авлигатай тэмцэх ажлаараа ухарч алхаж байгаа Т.Энхжаргал дарга ч өөрийг нь хамгаалж үлдэхийг мэдсэн юм шиг “Яахав ээ, яахав” гээд маасайж зогссон нь ч ийм учиртай байж. МАН-ынхан АТГ-ын дарга солигдож, тэд ажлаа хийсэн шиг хийхээс үхтлээ айж байгаа бололтой. Алдарт 60 тэрбумын хэргээс авхуулаад гэнэн авлигачид гишгэх газаргүй болсон энэ цагт АТГ хүсэх л юм бол ямар ч авлигын хэргийг илрүүлж болно. Харин МАН-д хэрэг илрүүлэхийг хүсэхгүй, “За мэдэхгүй ээ, мэдэхгүй” гэж хэлээд зогсч байх л хүн хэрэгтэй байна. Тэгж байж л оффшор дансандаа олон саяыг нуусан цагаан захтнууд, гадаадад элдэв байшин худалдаж авсан нь илрээд байгаа олон албан тушаалтнууд, “Эрдэнэт” үйлдвэрийн 51 хувийг гадны банкны барьцаанд тавьж, улсыг 100 гаруй сая ам.долларын өрөнд оруулчихаад байгаа эрх мэдэлтнүүд бүтэн нойртой хононо. Тиймдээ ч тэд үхэн хатан хамгаалж үлдэхээр шийдлээ. Харамсалтай нь тэд энэ үйлдлээрээ ард түмний дургүйг улам бүр хүргэж, тарах нүхээ гүнзгийрүүлж байна. Ард түмний дургүйцэл өдрөөс өдөрт нэмэгдэж, удахгүй УИХ-ыг тараахын төлөө нэгдэхгүй гэх газаргүй. Монголын ард түмэн хэдхэн төгрөгт хууртаж, боолын хөдөлмөр эрхэлж, авлигачид гэдсээ илж суухыг харж тэсэхээ больсон. Хүн бүр хөдөлмөрөө

шударгаар үнэлүүлж, нийгэмд шударга ёс тогтохыг харахыг хүсч байна. Цаг үе ингэж өөрчлөгдөж байхад ард түмний дийлэнх нь хүсч байгаа шударга ёсыг тогтоохын төлөө УИХ ажиллахгүй бол тарааж болох байлгүй. Монголын гурван сая иргэнд тийм хүч бий шүү. Та нар иргэдээ доромжил, дээрэлх, 20 мянган төгрөгөөр аргалж болно гэж бод. Тэгэх тусмаа тарах нүхээ улам гүнзгийрүүлнэ. АТГ-ын даргаа 2020 он хүртэл цээжээрээ хамгаалаад, “Яахав ээ, яахав” гээд суугаарай. Ерөнхийлөгч Х.Баттулга “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга У.Бямбасүрэн, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ганхуяг тэргүүтэй хүмүүсийг хүлээж авч уулзахдаа өөрийн хувилбарыг санал болгосон. Тэрбээр “Өнөөдөр иргэдэд хувьцааны 14.6 хувь нь байгаа юм байна, энэ хувийг өсгөж 100 хувь болгох ёстой. Энэ хуулийн төслийг би удахгүй УИХ-д өргөн барина. УИХ-аар энэ хуулийг баталчих юм бол 3000 төгрөгийн ногдол ашиг биш 300 000 төгрөгийн ногдол ашиг хуваарилах тухай яриад сууна. Бүх иргэддээ энэ хувьцааг 100 хувь өгөхөөр УИХ шийдсэн тохиолдолд сонгуулийн үед надад захиас даалгавар болгож өгсөн өр тэглэх тухай асуудал л гэхэд хэдхэн жилийн ногдол ашгаар шийдэгдэх боломжтой. Үндсэн хуулийн 6.1-д заасан “Байгалийн баялаг ард түмний өмч” гэдэг заалт ч жинхэнэ утгаараа хэрэгжинэ” хэмээн хэлсэн. Удахгүй хуулиа санаачилж, УИХ-д өргөн барих байх. МАН-ын 65 тэр хуулийг ч гэсэн хэлэлцэхгүй гээд унагаарай. Ард түмэнд ийм том компанийн хувьцааг 100 хувь өгөх хуулийн гаргалгаа байхгүй. Мухардалд орлоо гээд унагахгүй юу. Тэгвэл өнөөх тарах нүхний чинь гүн улам нэмэгдэх байх. Ерөнхийлөгчид УИХ-ыг тараах, тэндээс гарч буй буруу шийдвэрийг эргүүлэх эрх мэдэл байхгүй. Харин УИХ-д Ерөнхийлөгчийн зүгээс өргөн барьж байгаа хуулийн төсөл, саналыг “хогийн сав” руу шидэх эрх мэдэл байна. Зөв бүхнийг “хогийн сав” руу шидээд байвал юу болох билээ. Ард иргэдийн зэвүү, дургүй хоёрыг зэрэг л хүргэнэ. АТГ-ын даргын чинь хэлдгээр яахав ээ, хоёр жил УИХ гарчихалгүй тэсэх байх. Гэхдээ та нар дүнгээ тавиулах цаг удахгүй шүү. Хоёрхон жил авлигачид албан тушаалын хэрэгтнүүдээ хаацайлж үлдлээ гээд яах ч билээ. Цаг цагаараа байдаггүй. Юм өөрчлөгдөнө. Харин ганцхан зүйл л өөрчлөгдөхгүй. Хэрэг хэзээ ч хуучирдаггүй юм.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Хуульзүйн байнгын хороо чуулганы Дэгийн тухай хуулийг зөрчлөө

Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын ХЗБХ-ны хурлаар АТГ-ын удирдлагыг солих асуудлыг хэлэлцэхгүй гэж шийдсэн нь УИХ-ын чуулганы хуралдааны Дэгийн тухай хууль зөрчсөн гэж үзэж байна хэмээн Ерөнхийлөгчийн Тамгын газраас мэдээллээ. Ерөнхийлөгч Авлигатай тэмцэх газрын удирдлагыг солихоор УИХ-д саналаа хүргүүлснийг өчигдөр УИХ-ын Хуульзүйн байнгын хороо хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн. АТГ-ын удирдлагыг солих Ерөнхийлөгчийн саналыг Дэгийн тухай хуулийн 45.1 болон 45.2-т заасны дагуу хэлэлцэж, Ерөнхийлөгчийн саналыг дэмжих эсвэл дэмжихгүй шийдвэрийн аль нэгийг гаргах ёстой. Гэвч тус байнгын хороо уг хуулийг зөрчин хэлэлцэхгүй гэж шийдсэн байна хэмээн мэдэгдлээ. Улсын их хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журмын 45.1-д “Хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтныг томилох, чөлөөлөх санал гаргасан бол холбогдох Байнгын хороо долоо хоногийн дотор хэлэлцэж санал, дүгнэлт гаргана”. 45.2-т “Нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол батлагдсанд тооцно” хэмээн заасан байдаг ажээ.

Монгол эрчүүдийн 7.5 хувь нь үргүйдэлтэй байна

Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлгийг өчигдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн, НББСШУ-ы байнгын хорооны дарга Ё.Баатарбилэг удирдаж, УИХ-ын гишүүн Д.Ганболд, Б.Ундармаа, Н.Оюундарь, Б.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Б.Бямбадорж болон холбогдох яамд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, эрэгтэйчүүдийн эмнэлгийн эмч, эрдэмтэн судлаачид оролцлоо. Эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал сэдвээр илтгэл тавьсан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал, доктор Л.Насанцэнгэл монгол эрчүүдэд гол төлөв архаг ядаргаа, органик бус нойргүйдэл, архинд донтох эмгэг, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал тохиолдож байгааг онцолсон бол эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үйл ажиллагааны талаар илтгэсэн анагаах ухааны доктор Э.Одхүү монгол эрчүүдийн 7.5 хувь нь үргүйдэлтэй байна гээд, түүнд тамхи, архины хэрэглээ, химийн хорт нэгдэл, бэлгийн замын халдарт өвчин ихээхэн нөлөөлж байна гэлээ. Илтгэгчдийн мэдээллээс үзэхэд, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.1 байгаа бол эрэгтэйчүүдийнх 65.5 байгаа нь дэлхийн дунджаас 2.5 дахин их байгаа аж. Монгол Улсад жилд дунджаар 17 мянга гаруй хүн нас барж байгаагийн 62 хувь нь эрэгтэйчүүд бөгөөд шалтгаанаар нь ангилбал 33.1 хувийг зүрх судасны тогтолцооны өвчин, 25.6 хувийг хавдрын шалтгаан эзэлсэн байна. Түүнчлэн 20-45 насны эрэгтэйчүүдийн 80 хувь нь түрүү булчирхайн үрэвсэлтэй гэсэн судалгаа гарчээ.

Ерөнхий сайд V.Хүрэлсүх Баянхонгор аймагт ажиллалаа

Н.ПУНЦАГБОЛД

Ерөнхий сайд У.Хүрэлсүх баруун аймгуудад ажиллаж байгаа билээ. Тэрбээр өчигдөр Баянхонгор аймагт ажиллажээ. Ерөнхий сайд аймаг, орон нутагт ажиллахдаа тулгамдаж буй асуудлуудыг газар дээр нь шуурхай шийдвэрлэн ажиллаж байгаа юм. Мөн Засгийн газраас хэрэгжв-үлж байгаа малын өвчнөөс урьдчилан сэргийлэх жилийн арга хэмжээний нээлтийг тус аймагт хийв. Аймгийн Засаг дарга “Манай аймагт хүрэлцэн ирсэн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдэд нийт иргэдийнхээ өмнөөс талархаж байна. Малын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Засгийн газрын бодлого, ажил арга хэмжээ болгож байгаад баярлалаа, Засгийн газрын бүхий л бодлого, зорилтыг манай аймаг хэрэгжүүлж ажиллахад анхаарах болно. Мөн манай аймаг ХАА, МАА-н салбарыг голчлон хөгжүүлж ажиллана” гэв. Тэгвэл Засгийн газраас тус аймагт иж бүрэн трактор, гар трактор, хонь, ямаа хяргах төхөөрөмж, малын вакцин, хүн эмнэлгийн хоёр автомашин гардууллаа.



Баймаг хамгаалахын сайд

Н. Энхболд



Б.ДАВААХУЙ

Davaakhuu0128@gmail.com

ОХУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль өнгөрөгч гуравдугаар сард болж, В.Путин 76 хувийн саналаар үнэмлэхүй ялалт байгуулж, улиран сонгогдсон билээ. Ингэснээр тэрбээр 20 жил тус улсын Ерөнхийлөгчийн албыг хашихаар болсон юм. Тэгвэл өнгөрөгч даваа гарагт В.Путин Кремлийн ордны Андреевын танхимд тангараг өргөж, үүрэгт албандаа орсноор Засгийн газрын хуучин танхим ажлаа өгөв. Ерөнхийлөгч хоёр долоо хоногийн дотор шинэ Ерөнхий сайдын нэрийг дэвшүүлэх ёстой бөгөөд парламентын доод танхим Ерөнхий сайдад нэр дэвшигчийг долоо хоногийн дотор батлах үүрэгтэй байдаг.

Харин В.Путины хувьд Ерөнхийлөгчийн тангараг өргөснийхөө дараа ирэх зургаан жилд дахин Дмитрий Медведевийг Ерөнхий сайдаар улираан томилуулах хүсэлтээ төрийн Думд гаргасан нь дэлхий нийтийн анхаарлыг татлаа. Эдүгээ 52 настай Д.Медведев өнгөрсөн зургаан жилийн хугацаанд Засгийн газрыг толгойлсноос гадна түүнээс өмнөх дөрвөн жилд буюу 2008-2012 онд ОХУ-ын Ерөнхийлөгчөөр, харин В.Путин түүний Засгийн

газрын тэргүүний албыг хашч байсан удаатай. Нэгэнт Ерөнхийлөгч хүсэлтээ гаргасан тул төрийн Дум өчигдөр шинэ Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцсэн бөгөөд санал хураалт үдээс хойш болов. В.Путин өнөөдрийг хүртэл нийтдээ 14 жил ОХУ-ын төрийн тэргүүнээр, хоёр ч удаа Ерөнхий сайдаар ажилласан юм. Харин ирэх зургаан жилд дахин Д.Медведевийг Засгийн газрын тэргүүнээр томилсноор тэд нийтдээ 16 жил хамтран улсаа удирдахаар болж байна.

Нөгөөтэйгүүр, В.Путиныг төрийн тэргүүнээр ажиллаж байх хугацаанд тус улсын Засгийн газар харьцангуй тогтвортой ажиллаж иржээ. Түүний Ерөнхийлөгчөөр ажилласан 14 жил болон ирэх зургаан жилийг хамгийн ойрын жишээ болох хоёр ч удаа улиран сонгогдсон экс Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн бүрэн эрхийн хугацаатай харьцуулж үзье.

Экс Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2009 оноос 2017 оныг хүртэл нийт найман жил Монгол Улсын төрийн тэргүүнээр ажилласан юм. Харин энэ хугацаанд манай улс дөрвөн ч Ерөнхий сайдын нүүр үзжээ. Тодруулбал, түүнийг 2009 оны сонгуульд ялалт байгуулах үед манай улсын Ерөнхий сайдаар С.Баяр ажиллаж байлаа. Тангаргаа өргөснөөс нь хойш таван сарын дараа огцорч, С.Батболд шинэ Ерөнхий сайдаар томилогджээ. Түүнчлэн, хоёр дахь бүрэн эрхийн

хугацаанд нь мөн л хоёр сайд солигдсоны нэг нь Н.Алтанхуяг, нөгөө нь Ч.Сайханбилэг нар байв. Эсрэгээр В.Путин 20 жил ОХУ-ын Ерөнхийлөгчөөр ажиллахад таван Ерөнхий сайд солигдох нь. Түүний 2000-2008 оныг хүртэлх найман жилийн бүрэн эрхийн хугацаанд Засгийн газрын тэргүүнээр нь Михаил Касьянов, Михаил Фрадков, Виктор Зубков нар ажилласан бол үлдсэн хугацаанд нь ганц Д.Медведев гүйцэтгэх засаглалыг толгойлох нь ээ. ОХУ болон Монгол Улсын хувьд засаглалын хувьд адилгүй. Гэвч ардчилал гэдэг томдсон малгайны уршиг Монгол Улсад ямар үр дүн гаргасныг энэ хоёр эрхмийн төрийн тэргүүн байсан он жилүүдээс харьцуулж болмоор санагдана. Нэг нь 20 жил төр удирдахдаа таван Ерөнхий сайдын нүүр үзэх нь. Улсынх нь хөгжил дэлхий дахинд гайхагдаж байна. Харин нөгөө нь наймхан жил Төрийн тэргүүнээр ажиллахдаа өөрийн, өрөөлийн намын дөрвөн ч Ерөнхий сайдтай хамтарч ажиллав. Үр дүнд нь Монгол Улсын эдийн засаг унаж, үйлдвэрүүд дампуурч, уул уурхайн төслүүд нь эхнээсээ зогслоо. Засгаа олон сольсноор улс хөгждөггүй гэдгийн тод томруун жишээ нь Монгол Улс болж түүхэнд бичигдэж үлджээ. Тооны хувьд тэнцүүхэн ч цаг хугацааны хувьд асар хол зөрүү байгааг уншигч та эндээс ажигласан биз. Хамгийн хоржоонтой нь Ц.Элбэгдоржийн ард бамбай

нь болж явсан, 2013 онд түүнд дахин ялалт авч ирсэн намынхаа эсрэг тэр олон жил ажиллаж байлаа. Тэр ч байтугай өөрийн намынхаа Засгийн газрыг огцруулахад оройлон оролцож, дэгээ тавьсан хүн нь Ц.Элбэгдорж байсан гэдгийг ч Н.Алтанхуяг индрийн ардаас зоригтой мэдэгдэж байв. Монгол Улс тогтвортой хөгжлийн тухай олон жил ярьж байгаа. Ялсан нам болгон төрөө тогтвортой удирдана гэж амлалт өгдөг. ОХУ-ыг В.Путин удирдах сургаар ч түүн шиг удирдагчийг үгүйлж эхлэв. Гэвч ардчиллын зам сонгосон улсад хэдэн мянган В.Путин байгаад ч нэмэргүй. Улс төрийн хоёр намын хэмжээлшгүй эрх мэдэл, түүн дотроо цөөхөн хэдэн олигархи улстөрчдийн тоглоомын дүрэм үйлчилж байгаа цагт урт хугацаанд тогтвортой хөгжих тухайд яриад ч нэмэргүй биз ээ. Магадгүй нэг хүнхэдэн ч удаа Ерөнхийлөгчөөр улирч сонгогддог тогтолцоотой, түүний 16 жилд нь Ц.Элбэгдорж Төрийн тэргүүнээр ажилласан бол 20 байтугай Ерөнхий сайдтай, улс нь баялгийн хараалд автаж, өнөөдрийн байгаагаас ч долоон дор нөхцөл байдалтай суух байсныг хэн ч үгүйсгэхгүй. Золоор тийм зүйл тохнохгүй. Гэвч, түүний засагласан найман жилийн үр дүн бидэнд Үндсэн хуулиа өөрчилж, сонгуулийн мөчлөгөө уртасгаж, хамгийн чухал нь тогтвортой засаглал бий болгох ёстойг сануулж, гашуун сургамжийг ч өглөө.



Монгол Найман жил		Орос 20 жил	
Ц.Элбэгдорж /2009-2013/	С.Баяр /2007.11.22 – 2009.10.29/	В.Путин /2000-2004/	Михаил Касьянов /2000-2004/
	С.Батболд / 2009– 2012/	В.Путин /2004-2008/	Михаил Фрадков /2004-2007/ Виктор Зубков /2007-2008/
Ц.Элбэгдорж /2013-2017/	Н.Алтанхуяг /2012– 2014/	В.Путин /2012-2018/	Д.Медведев
	Ч.Сайханбилэг /2014 – 2016/	В.Путин /2018-2024/	Д.Медведев

Улаанбаатар хотын авто засварын үйлчилгээний байгууллагуудын чанар ба үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж

СЭЗИС-ийн магистрант А.УРАНЦЭЦЭГ

тал дээр сурахцаа шаардлага чухал байна.

Манай улсад автомашины насжилт ихтэй, түүнчлэн автоамын чанарын шаардлага хангаагүй байдлаас болж авто засварын бизнесийн эрэлт хэрэгцээ их байдаг. Судалгаанаас харахад одоогоор манай улсад 2222 авто үйлчилгээ үзүүлэгч байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн 743 нь автозасварын үйлчилгээ эрхлэгч байгууллага, хувь хүн байна. Тэр дундаа 20 хувь нь аж ахуйн нэгж байгууллага, 80 хувь нь иргэд байна. Үүнээс албан ёсны төлөөллийн компани зургаа, авто үйлчилгээний төвийн нэгдсэн цогц үйл ажиллагааг эрхэлж буй компани 13 байна. Өрсөлдөөн ихсэхийн хэрээр компаниуд үйл ажиллагаагаа сайжруулж, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг өндөр төвшинд хангахад илүүтэй анхаарч ажиллах болжээ.

Компанийн удирдлагууд хэрэглэгчээ барьж үлдэх нь шинэ хэрэглэгч олж авахаас илүү чухал гэдгийг бүгд мэддэг. Яагаад гэвэл нэгт, одоогийн хэрэглэгч нар үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээнд зарцууладаг зардлаа тасралтгүй өсгөж байдаг, түүнчлэн урамшуулал шингээгүй үндсэн үнээр үйлчилгээг худалдан авдаг нь компанийн үйл ажиллагааны ашгийг өсгөж байдаг (Keaveney, 1995). Хоёрт шинэ хэрэглэгч бүртгэх, шинэ хэрэглэгч татахын тулд гаргаж байгаа маркетинг сурталчилгааны зардал болон урамшууллын зардал гэх мэт шинээр хэрэглэгч олж авах зардал нь одоогийн хэрэглэгчээ хадгалж үлдэх зардлаас бараг тав хүртэл дахин өндөр туслах тохнодлол гардаг (Tom, 1988). Хэрэглэгчийн үнэнч байдал гэдэг нь автозасварын бизнесийн хамгийн чухал үзүүлэлт байдаг. Учир нь автомашины найдвартай ажиллагаа нь хүний эрүүл мэнд, амь настай холбоотой. Иймээс хүмүүс өөрийн үйлчлүүлж буй байгууллагаа үнэнч байх сонирхол ихтэй байдаг.

Автозасварын бизнес нь автомашины эмнэлэгтэй адил бизнес бөгөөд хариуцагатай үйлчилгээг чанартай төвшинд үзүүлэх нь гол зорилт болдог. Автозасварын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын сэлбэг хэрэгсэл, бүтээгдэхүүний хувьд өрсөлдөөн илүүтэй үйлчилгээний чанараар өрсөлдөх байдал илүү чухал байдаг.

Миний бие Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй авто засварын цогц үйлчилгээ үзүүлж буй төвүүд болон автомашины борлуулалтын албан ёсны төлөөллийн компанийн дэргэдэх авто засварын үйлчилгээгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс санал асуулга авч үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг тодорхойлох судалгааг хийсэн ба судалгааны үр дүнгээс дараах зүйлсийг онцлон дүгнэж байна.

- Судалгаанд оролцогчдын авто засварын үйлчилгээний талаарх хүлээлт нь бодит хүртэхүйгээсээ дунджаар 10-13 хувиар доогуур үзүүлэлттэй гарсан ба үйлчилгээний чанарын хувьд үйлчлүүлэгчдийнхээ хүлээлтэй хангахгүй байгааг харуулж байна.
- Авто засварын газруудын дотоод тохижилт, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байдал, ажилтнуудын ажилдаа сэтгэлээсээ ханддаг байдал, үйлчлүүлж буй байгууллагадаа итгэлтэй санаа амар байж болдог байдал, шуурхай байдал, цагийн хуваарийн тохиромжтой байдал зэрэг нь хамгийн ихээр дутагдажтай гарсан байна.
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 76.2 хувьтай гарсан бол хэрэглэгчийн үнэнч байдлын үзүүлэлт 84.7 хувийн дундажтай гарчээ.
- Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үнэнч байдал, үйлчилгээний чанарын өнөөгийн байдлын үнэлгээг авто үйлчилгээний нэгдсэн цогц төвүүд болон албан ёсны төлөөллийн компаниудын хувьд тусад нь тооцож ялгаатай байдлыг дүгнэхэд албан ёсны төлөөллийн компаниудын хувьд илүү өндөр үнэлгээг авч байна. Иймээс цаашид Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй авто үйлчилгээний цогц төвүүд өөрсдийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор албан ёсны төлөөллийн байгууллагуудын үйлчилгээний стандарт, орчин нөхцөл, тоног төхөөрөмж, үйлчилгээний менежментийн

Иймээс авто засварын бизнес эрхэлж буй байгууллагуудын хувьд хэрэглэгчийн үнэнч байдал, сэтгэл ханамжинд илүү хүчтэй нөлөө үзүүлж болох үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэхэд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Мэдэгдэхүйц байдлыг сайжруулах замаар хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг сайжруулах хүрээнд:

- Авто засварын газруудын хувьд орчин үеийн шаардлага хангасан тоног төхөөрөмжүүдэд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.
- Автозасварын газруудын дотоод тохижилтын шаардлага хангахгүй байдал түгээмэл байна. Эмх цэгцгүй, үнэр, тоосжилт зэрэг наад захын шаардлагуудыг хангахгүй байна. Иймд дотоод тохижилтыг сайжруулах, үйлчлүүлж буй хүмүүст зориулсан уулзалтын өрөө, амрах өрөө зэргийг сайжруулах боломжтой юм.
- Сэлбэг хэрэгсэл, шаардлагатай материалуудын эмх цэгцтэй байдлыг сайжруулах хэрэгтэй байна. Ажлын байрны эмх цэгцтэй байдлыг сайжруулах, хэвшүүлэх чанарын удирдлагын 5 С аргыг нэвтрүүлэх хэрэгтэй.
- Засварын ажилтнууд нь үйлчилгээгчдийг угтан авч, автомашинд гарсан асуудлын нь шийдэж өгөх талаар үйлчилгээний стандартдаа тусгаж өгөх. Эсвэл үйлчлүүлэгч бүрийг угтан авч, холбогдох газар, хариуцах хүмүүст холбож өгөх утгах үйлчилгээний чиглэлээр ажиллантай болох боломжтой юм.

Найдвартай байдлыг сайжруулах замаар хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг сайжруулах хүрээнд:

- Хэрэглэгчдийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах цагийг илүү бодитой амлах шаардлагатай. Учир нь засварын ажилтнууд хэрэглэгчдэд тодорхой амлалт өгдөггүй, баримжаа цаг хэлдэг нь найдвартай байдлыг бууруулах гол шалтгаан болдог.
- Авто засварууд оношлогоонд суурилан тодорхой амлалт өгч ажиллах нь чухал юм.
- Ажилтнуудын ажлын цагийг зохицуулалтыг оновчтой болгох, засварын ажилтнуудаар тасралтгүй хангах байдлыг хүний нооцийн удирдлагын хүрээнд үргэлж анхаарч ажиллах нь чухал юм. Ингэснээр хэрэглэгчдэд амласан цаг хугацаандаа үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой юм.

Мэдэрэмжтэй байдлыг сайжруулах замаар хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг сайжруулах хүрээнд

- Үйлчлүүлэгчидтэй харилцах талаар засварын ажилтнуудын харилцааг сайжруулах, харилцахын хувьд эргэх холбоог сайтар хийж сургах нь чухал.
- Түүнчлэн үйлчлүүлэгчидэд туслах сонирхолтой байгааг тодорхой илэрхийлж, хугацаандаа, шуурхай ажил гүйцэтгэж сурахад анхаарах шаардлагатай.
- Баталгаатай байдлыг сайжруулах замаар хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдлыг сайжруулах хүрээнд
- Оношлогоонд суурилан, нарийн мэдлэгийн хүрээнд баталгаатай харилцлыг үйлчлүүлэгчдэд өгдөг байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл баталгаагүй, таамаг тодй мэдээллийг хүмүүст хүргэснээр энэ үзүүлэлт буурдаг болох нь харагдаж байна.
- Үйлчлүүлэгчдийн хувьд автомашин, өөрийн эд хөрөнгөндөө баталгаатай ханддаг байгаа эсэхийг мэдэхгүйгээс болж авто засварын газруудад итгэлгүй ханддаг. Хүмүүсийн автомашин, эд хөрөнгийн хүлээн авах, хүлээлгэж өгөх процессийг нарийвчлах, шалгах хуудас нэвтрүүлэх, гарын үсэг зурж баталгаажуулах зэргийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах шаардлагатай.
- Автозасварын бизнесийн хувьд хэрэглэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдал, үйлчилгээний чанарын судалгааг тодорхой цаг хугацаанд давтамжтай хийж гүйцэтгэх нь цаашид байгууллагын тасралтгүй хөгжлийг хангах гол хүчин зүйлс юм.

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:2018 оны 05 дугаар сарын 01-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Хот тохижуулах газарт машин механизм худалдан авах /Өөрөө буулгагч машин 2, Трактор 1 ширхэг/
Тендер шалгаруулалтын дугаар: OP-71/2018

Орхон аймгийн ЗДТГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Хот тохижуулах газарт машин механизм худалдан авах / Өөрөө буулгагч машин 2, Трактор 1 ширхэг/ тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Санхүүгийн тайлан: 2016, 2017 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг ирүүлэх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй хэмжээний ижил төрлийн барааг нийлүүлсэн туршлагатай байх

Тендерийн хамт 5,241,000 төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгаа ирүүлнэ.
Тендерийг 2018 оны 06-р сарын 01-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлшуулан тендерийг 2018 оны 06-р сарын 01-ны 09 цаг 30 минутад Орхон аймгийн ЗДТГ-ын Нэг цонх ОНӨГ-ын Сургалт мэдээллийн танхимд цахимаар нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас: 70358570

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018-05-04

Тендер шалгаруулалтын нэр: 8 дугаар сургуулийн гадна талбайд биеийн тамирын талбайг иж бүрэн тохижуулах
Тендер шалгаруулалтын дугаар: OP-16/2018

Орхон аймгийн засаг даргын тамгын газар эрх бүхий тендерт оролцогчдоос 8 дугаар сургуулийн гадна талбайд биеийн тамирын талбайг иж бүрэн тохижуулах-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жилийн тайланг (2016, 2017 он) ирүүлнэ.
Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: БХБЯ-ны 2.1.1
Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2018 оны 06-р сарын 04-ний өдрийн 08 цаг 30 минутаас өмнө цахим худалдан авах систем (www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлшуулан тендерийг 2018 оны 06-р сарын 04 -ны өдрийн 09 цаг 00 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Утас:70358570

